



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 386

Улаанбаатар хот

Хаалттай өрийн бичгийг бүртгэх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 165 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ын 3.1, 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Бизнес-Инвест девелопмент ББСБ” ХХК-ийн хаалттай хүрээнд санал болгон гаргах 12-18 хүртэлх сарын хугацаатай, жилийн 14-19 хувийн хүүтэй, нэг бүр нь 10,000 (арван мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,000,000 (нэг сая) ширхэг хаалттай өрийн бичгийг нэмж бүртгэсүгэй.

2. Хаалттай өрийн бичиг гаргахтай холбогдуулан хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Бизнес-Инвест девелопмент ББСБ” ХХК (Ц.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН